



Хүний эрхийн зөвлөл

5/1. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн бүтэц тогтолцоог бүрдүүлэх

Хүний эрхийн зөвлөл нь,

НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 2006 оны 3 сарын 15-ны өдрийн 60/251 тоот тогтоолоор олгогдсон эрх, үүргийнхээ дагуу,

Зөвлөлийн Ерөнхийлөгчөөс өргөн барьсан бүтэц тогтолцоог тодорхойлсон баримт бичгийн төслийг хэлэлцээд,

1. Энэхүү тогтоолын хавсралтад дурьдсан “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл: Бүтэц тогтолцоог бүрдүүлэх” баримт бичгийг батласугай.
2. Энд дурьдсан зүйлсийг шуурхай хэрэгжүүлэх шаардлагын үүднээс энэхүү баримт бичгийг НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаар батлуулахаар өргөн барьсугай:

Ерөнхий Ассемлей нь,

Хүний эрхийн зөвлөлийн 2007 оны 6 сарын 18-ны өдрийн 5/1 тоот тогтоолыг хэлэлцээд,

1. Энэхүү тогтоолын хавсралтад дурьдсан “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Бүтэц тогтолцоог бүрдүүлэх” баримт бичгийг бусад мэдээллийн хамт талархан хүлээн авсугай.

2007 оны 6 сарын 18-ны өдрийн 9-р чуулган

(Энэхүү тогтоол нь санал хураалтгүйгээр батлагдсан)¹

Хавсралт

НҮБ-ын ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛ: БҮТЭЦ ТОГТОЛЦОО

1. ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ ДҮГНЭЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

А. Хэлэлцүүлгийн үндэслэл

1. Дараахь гэрээнүүд нь хэлэлцүүлгийн эрх зүйн үндэслэл мөн:

(a) НҮБ-ын дүрэм;

¹ Хүний эрхийн зөвлөлийн A/HRC/5/21 тогтоолын III бүлгийн 60-62 дугаар параграфыг харна уу .

- (б) Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал;
 - (в) Дүгнэлт хэлэлцүүлэгт орж буй тухайн улсын нэгдэн орсон хүний эрхийн гэрээ хэлэлцээрүүд;
 - (г) Тухайн улсаас Хүний эрхийн зөвлөлийн (цаашид Зөвлөл гэх) гишүүнд нэр дэвшихдээ гаргасан болон бусад үүрэг амлалтууд;
2. Түүнчлэн олон улсын хүний эрхийн хэм хэмжээ болон олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн харилцан хамааралт байдлаас хамааран хэлэлцүүлэгт олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хэрэглэж болно.

Б. Зорилго, зарчмууд

1. Зарчмууд

3. Ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн зарчим нь:
- (а) Хүний эрхийн түгээмэл болон харилцан хамааралтай, уялдаа холбоотой, хуваагдашгүй байдлыг дээдлэх;
 - (б) Үнэн бодит найдвартай мэдээлэл болон харилцан яриа хэлэлцээрт тулгуурласан хамтын механизм байх;
 - (в) Бүх нийтийг хамран, бүх улсад тэгш үйлчлэхийг анхаарах;
 - (г) НҮБ-ын гишүүдэд хандсан, бодит үйл ажиллагаанд чиглэсэн Засгийн газар хоорондын үйл ажиллагаа байх;
 - (д) Дүгнэлт хэлэлцүүлэгт орж буй улсын оролцоог бүрэн хангах;
 - (е) Иж бүрэн бөгөөд хүний эрхийн бусад механизмуудыг давхцахгүй, харин түүнийг сайжруулахад хувь нэмэр оруулах;
 - (ё) Тодорхой зорилготой, ил тод, үл сонгох, харилцан яриа хэлэлцээнд тулгуурласан, ажил хэрэгч, зөрчилдөөнгүй, улс төржөөгүй байдлаар явагдах;
 - (ж) Зөвлөлийн үйл ажиллагаа болон дүгнэлт хэлэлцүүлэгт орж буй улсад хэт дарамт үүсгэхгүй байх;
 - (з) Бодит байдалд нийцсэн байх ба хэт сунжирсан бус, хэт их хүний болон санхүүгийн нөөцийг зарцуулахгүй байх;
 - (и) Хүний эрхийн зөрчлийн онцгой байдалд арга хэмжээ авах Зөвлөлийн чадавхид нөлөөлөхгүй байх;
 - (й) Хүйсийн тэгш байдлыг бүрэн хангах;
 - (к) Дүгнэлт, хэлэлцүүлгийн эрх зүйн үндэслэлийн заалтууд дахь үүргийг муйхарлан тулгах бус тухайн улсын онцлог, хөгжлийн түвшинг анхаарч үзнэ;
 - (л) Ерөнхий Ассемблейн 2006 оны 3 сарын 15-ний 60/251 тоот тогтоол, Эдийн Засаг Нийгэм, Соёлын Зөвлөлийн 1996 оны 7 сарын 25-ны 1996/31 тоот болон үүнтэй холбоотойгоор Зөвлөлөөс гаргасан бусад шийдвэрүүдийн дагуу хүний эрхийн үндэсний байгууллагууд болон төрийн бус байгууллагууд зэрэг холбогдох бүхий л талуудын оролцоог хангах зарчимд тулгуурлана.

2. Зорилго

4. Дүгнэлт хэлэлцүүлгийн зорилго нь:
- (а) Хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах;
 - (б) Хэлэлцүүлэгт орж байгаа улсад тулгарч буй саад бэрхшээл, ахиц дэвшлийг үнэлэн хүний эрхийн үүрэг, амлалтын хэрэгжилтийг хангуулах;
 - (в) Хэлэлцүүлэгт орж байгаа улстай харилцан зөвшилцсөний үндсэн дээр чадавхийг нь дээшлүүлэх болон техникийн туслалцаа үзүүлэх;
 - (г) Хүний эрхийг хангах, хамгаалах талаархи сайн туршлагыг улс гүрнүүд болон бусад холбогдох талуудад түгээн дэлгэрүүлэх;

(д) Хүний эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн улс орнуудын хамтын ажиллагааг дэмжих;

(е) НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар, Хүний эрхийн зөвлөл, хүний эрхийн бусад байгууллагуудтай үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оршино.

В. Дүгнэлт, хэлэлцүүлгийн мөчлөг, ээлж дараалал

5. Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн журам Зөвлөлөөр батлагдмагц дүгнэлт хэлэлцүүлэг явагдаж эхэлнэ.
6. Дүгнэлт хэлэлцүүлгийн ээлж дараалал нь бүх гишүүн орнуудыг хамрах, бүх улсад тэгш үйлчлэх зарчимд үндэслэнэ.
7. Улс орнуудад дүгнэлт хэлэлцүүлэгт хангалттай бэлтгэх боломж олгох үүднээс дарааллыг аль болох эрт тогтооно.
8. Зөвлөлийн гишүүн бүх улс гишүүнийхээ бүрэн эрхийн хугацаанд дүгнэлт хэлэлцүүлэгт орно.
9. Зөвлөлийн анхны гишүүд, ялангуяа 1 болон 2 жилийн хугацаагаар сонгогдсон гишүүн улсууд эхний ээлжинд хэлэлцүүлэгт орно.
10. Зөвлөлийн гишүүд ба ажиглагч улсууд хэлэлцүүлэгт орно.
11. Дүгнэлт хэлэлцүүлгийн ээлж дарааллыг тогтооход газар зүйн тэнцвэрт байдлыг харгалзан үзнэ.
12. Газар зүйн тэнцвэрт байдлыг хангахын тулд эхний ээлжинд хэлэлцүүлэгт орох гишүүн болон ажиглагч улсуудыг Бүсийн бүлгүүдээс сугалаагаар сонгон авна. Сайн дураараа хэлэлцүүлэгт орохоос бусад тохиолдолд хэлэлцүүлэгт орохоор сонгогдсон улсууд нь цагаан толгойн үсгийн дарааллаар хэлэлцэгдэнэ.
13. Ээлжит хэлэлцүүлгийн мөчлөг хоорондын хугацаа нь тухайн улсын дараачийн хэлэлцүүлэгт бэлтгэх чадавхи болон өмнөх хэлэлцүүлэгээс гарсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд боломжтой байх ёстой.
14. Хэлэлцүүлгийн эхний мөчлөг нь 4 жил байна. Учир нь нэг жилд 48 улс хэлэлцүүлэгт орох бөгөөд ажлын хэсэг нь жилд 3 удаа хуралдана. Ажлын хэсгийн нэг удаагийн хуралдааны үргэлжлэх хугацаа нь 2 долоо хоног байна.²

Г. Хэлэлцүүлгийн явц болон загвар (modalities)

1. Баримтжуулалт

15. Дүгнэлт хэлэлцүүлэг нь:

(а) Зөвлөлийн 6-р хурлаар (2 дахь мөчлөгийн эхний хуралдаан) батлагдах удирдамжийн дагуу бэлтгэгдсэн үндэсний илтгэл буюу хэлэлцүүлэгт орж буй Улсын мэдээлэл болон хэлэлцүүлэгт орж буй Улстай холбогдолтой аман болон бичгээр ирүүлсэн бусад мэдээллүүд дээр үндэслэн явагдана. Бүх улсуудад адил тэгш хандах, хэт ачаалал үүсгэхгүй байх үүднээс бичгээр ирүүлсэн мэдээлэл нь 20 хуудаснаас ихгүй байна. Улсууд нь мэдээллээ үндэснийхээ хэмжээнд холбогдох бүх талуудтай өргөнөөр хэлэлцэн бэлтгэнэ.

(б) НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар нь гэрээний хэрэгжилтийг хянах хороод, тусгай үүрэг гүйцэтгэгчдийн илтгэл, тухайн улсаас гаргасан санал, хүсэлт болон НҮБ-ын холбогдох бусад байгууллагуудын мэдээллийг эмхэтгэн 10-аас дээшгүй хуудастай илтгэл бэлтгэнэ.

² Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг нь хувьсах үйл явц бөгөөд эхний мөчлөгийн туршлага дээр үндэслэн Зөвлөл энэхүү механизмын журам, үргэлжлэх хугацаа зэргийг дахин хэлэлцэж сайжруулна.

- (в) Бусад талуудаас Ээлжит нэгдсэн хэлэлцүүлэгт хандан ирүүлсэн үнэн, бодитой мэдээллийг Зөвлөл авч хэлэлцэнэ. Хүний Эрхийн Дээд Коммиссарын газраас дээрх мэдээллүүдийг 10 хуудсанд багтаан амхэтгэнэ.
16. Хүний Эрхийн Дээд Коммиссарын газрын эмхэтгэл нь Хүний эрхийн зөвлөлөөр батлагдсан дүгнэлт хэлэлцүүлгийн мэдээлэл бэлтгэх ерөнхий удирдамжийн дагуу боловсруулагдана.
17. Ерөний Ассемблейн 1999 оны 1 сарын 14-ний өдрийн 53/208 тоот тогтоолийн дагуу НҮБ-ын албан ёсны 6 хэлээр тараагдах шаардлагын үүднээс хэлэлцүүлэгт орж буй улс болон Хүний эрхийн дээд комиссарын газрын эмхэтгэл мэдээлэл нь Ажлын хэсгийн хэлэлцүүлэг явагдахаас 6 долоо хоногийн өмнө бэлэн болсон байх ёстой.

2. Загвар (modalities)

18. Хэлэлцүүлэг нь дараахь байдлаар явагдана:
- (а) Хэлэлцүүлэг нь Зөвлөлийн Ерөнхийлөгчөөр ахлуулсан 47 гишүүн улсуудаас бүрдсэн ажлын хэсэг дээр явагдах бөгөөд гишүүн улс тус бүр тухайн улсыг төлөөлөн хэлэлцүүлэгт орох төлөөлөгчөө томилно.³
- (б) Ажиглагч улсууд хэлэлцүүлэгт болон харилцан ярилцлагад оролцож болно;
- (в) Бусад талууд Ажлын хэсгийн хэлэлцүүлэгт оролцож болно;
- (г) Ажлын хэсгийн илтгэлийг бэлтгэх үүрэгтэй, өөр өөр бүс нутгийн төлөөлөл бүхий гурван илтгэгчийг (Гурвал) Зөвлөлийн гишүүд дундаас шодох аргаар сонгоно. Хүний эрхийн дээд комиссарын газар нь илтгэгчдийг (гурвал) шаардлагатай тусламж, мэдээллээр (expertise) хангана.
19. Дүгнэлт хэлэлцүүлэгт орж буй улс нь 3 илтгэгчийн нэгийг өөрийн харъяалагддаг Бүс нутгийн бүлгээс сонгохыг санал болгож болох бөгөөд онцгой тохиолдолд нэг удаа түүнийг орлох илтгэгчийг мөн санал болгож болно.
20. Илтгэгч нь хэлэлцүүлэгт оролцохоос татгалзах эрхтэй.
21. Ажлын хэсгийн хэлэлцүүлэг дээр Зөвлөл болон хэлэлцүүлэгт орж буй улсын хооронд асуулт хариулт, харилцан ярилцлага явагдана.
22. Гурвал илтгэгчид дүгнэлт хэлэлцүүлэгт бэлтгэхдээ хэлэлцүүлэгт орж буй Улсад тавигдах асуулт болон хэлэлцэгдэх асуудлуудыг урьдчилан бэлтгэж болно. Ингэхдээ ил тод, шударга байх зарчмыг баримтлана. Ажлын хэсэг дээр 1 улсын илтгэлийг 3 цаг хэлэлцэнэ. Зөвлөлийн бүгд хурлын үр дүнг хэлэлцэхэд 1 хүртэл нэмэлт цаг олгож болно.
23. Ажлын хэсэгт хэлэлцүүлэгт орсон улсын илтгэлийг батлахад 1 цаг 30 минут олгоно.
24. Ажлын хэсгийн дүгнэлт хэлэлцүүлэг хооронд болон хэлэлцүүлэгт орсон Улсын илтгэлийг батлахад боломжит хугацаа өгнө.
25. Эцсийн шийдвэрийг Зөвлөлийн бүгд хурлаар хэлэлцэн гаргана.

Д. Хэлэлцүүлгээс гарах шийдвэр

1. Шийдвэрийн хэлбэр

26. Дүгнэлт хэлэлцүүлгийн эцсийн баримт бичиг нь хуралдааны тэмдэглэл, хэлэлцүүлгээс гарсан дүгнэлт, зөвлөмж түүнчлэн хэлэлцүүлэгт орсон улсын үүрэг амлалт зэргийг багтаасан илтгэл хэлбэртэй байна.

³ Хөгжиж буй орнууд, нэн ялангуяа буурай хөгжилтэй орнуудын Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт орох оролцоог хангах зорилго бүхий "Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн Сайн дурын итгэлийн сан" байгуулагдан ажиллах болно.

2. Шийдвэрийн агуулга

27. Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг нь хамтын үйл явц мөн. Иймд хэлэлцүүлгээс гарах шийдвэр нь дараахь агуулгатай байна:
- (а) Хэлэлцүүлэгт орж буй улсад тулгарч буй бэрхшээл, гарч буй эерэг өөрчлөлт зэрэг тухайн улсын хүний эрхийн байдал, хүний эрхийн нөхцөл байдлын ил тод байдал
 - (б) Сайн туршлагаас суралцах, солилцох
 - (в) Хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахын төлөөх хамтын ажиллагааг бэхжүүлэхэд анхаарах
 - (г) Хэлэлцүүлэгт орж буй улстай зөвшилцсөний үндсэн дээр чадавхийг сайжруулах, техникийн туслалцаа үзүүлэх;⁴
 - (д) Хэлэлцүүлэгт орсон улсын сайн дурын үндсэн дээр авсан үүрэг амлалтууд;

3. Дүгнэлт хэлэлцүүлгийн шийдвэрийг батлах

28. Хэлэлцүүлэгт орж буй улс хэлэлцүүлгийн шийдвэрийг батлахад оролцоно.
29. Хэлэлцүүлэгт орсон улс нь эцсийн шийдвэрийг Зөвлөлийн Бүгд Хуралдаанаар батлахаас өмнө харилцан ярилцлагын үед хариулж чадаагүй асуудлуудад хариулт өгөх боломжоор хангагдсан байна.
30. Зөвлөлийн бүгд хуралдаанаар хэлэлцүүлгийн шийдвэрийг батлахаас өмнө хэлэлцүүлэгт орсон Улс болон Зөвлөлийн гишүүд, ажиглагч улсууд хэлэлцүүлгийн шийдвэрийн талаар дүгнэлт, саналаа илэрхийлэх боломжтой.
31. Холбогдох бусад талууд дүгнэлт хэлэлцүүлгийн шийдвэрийг Зөвлөлийн бүгд хурлаар батлахаас өмнө санал дүгнэлт хэлэх эрхтэй.
32. Зөвлөмжүүдийг хэлэлцүүлэгт орсон Улс хүлээн зөвшөөрсөн болон тодорхой санал хүсэлт гаргасан хэмээн тэмдэглэх бөгөөд аль аль нь Зөвлөлөөр батлагдах хэлэлцүүлгийн илтгэлд тусгагдана.

Е. Хэлэлцүүлгийн дараах алхмууд

33. Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг нь хамтын үйл ажиллагаа болохын хувьд хэлэлцүүлгээс гарсан шийдвэрийг тухайн Улс бүрэн, бусад холбогдох талууд боломжийн хирээр хэрэгжүүлнэ.
34. Дараагийн дүгнэлт хэлэлцүүлгээр өмнөх хэлэлцүүлгийн шийдвэрийн хэрэгжилтийг дүгнэн хэлэлцэнэ.
35. Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг нь Зөвлөлийн хөтөлбөрт байнга тусгагдсан байна.
36. Олон улсын хамтын нийгэмлэгээс хэлэлцүүлэгт орсон улстай харилцан завшилцсөний үндсэн дээр хэлэлцүүлгээс гарсан дүгнэлт зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд чадавхийг сайжруулах болон техникийн туслалцаа үзүүлнэ.
37. Зөвлөл нь Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн үр дүнг хэлэлцэхдээ түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн тусгай үйл ажиллагаа шаардлагатай эсэхийг шийдвэрлэнэ.
38. Хэлэлцүүлэгт орсон Улсаас Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн механизмтай хамтран ажиллахыг бүх талаар дэмжих ба хамтран ажиллахаас татгалзсан тохиолдолд ч боломжийн хирээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

⁴ Одоогийн хэрэгжиж байгаа санхүүгийн механизмыг хэрэглэх эсвэл шинээр механизм үүсгэх эсэхийг Зөвлөл шийдвэрлэнэ.

II. ТУСГАЙ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧИД

А. Тусгай үүрэг гүйцэтгэгчдийг сонгох, томилох

39. Тусгай үүрэг гүйцэтгэгчдэд нэр дэвшүүлэх, сонгох, томилоход дараахь шалгууруудыг нэн түрүүнд харгалзан үзнэ: (а) Мэргэшсэн байдал; (б) Тухайн салбар дахь туршлага; (в) Хараат бус байдал; (г) Шударга байдал; (д) хувийн байдал; (е) бодит байдал.
40. Газар зүйн бүсийн төлөөлөл болон хүйсийн тэнцвэрт байдал, түүнчлэн эрх зүйн тогтолцооны төлөөллийг хангахад анхаарна.
41. Хүний эрхийн салбарт өргөн мэдлэг туршлагатай, зарчим, мэргэшсэн хүнийг нэр дэвшигчдээр сонгохын тулд нэр дэвшигчдэд тавигдах техникийн болон бусад шаардлагуудыг Зөвлөлийн 6-р бүгд Хурлаар батлана. (2 дахь мөчлөгийн эхний хуралдаан)
42. Дараахь байгууллага, нэгжүүд тусгай үүрэг гүйцэтгэгчийн эрхийг хэрэгжүүлэгчдэд нэр дэвшүүлж болно: (а) Засгийн газрууд; (б) НҮБ-ын хүний эрхийн тогтолцоон дахь Бүс нутгийн бүлгүүд; (в) олон улсын байгууллагууд, тэдгээрийн салбарууд (Хүний Эрхийн Дээд Комиссарын газар гэх мэт); (г) төрийн бус байгууллагууд; (д) хүний эрхийн бусад байгууллагууд; (е) бие даан нэр дэвших.
43. Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар нь нэр дэвшигчдийн талаархи мэдээлэл, мэргэшил, ажлын туршлага зэрэг мэдээллүүдийг багтаасан нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг тогтсон шаардлагын дагуу бэлтгэх бөгөөд цаг тухай бүрд нь шинэчилж байна. Тусгай үүрэг гүйцэтгэгчийн эрх хэрэгжүүлэгчийн шинээр гарсан орон тоог хэвлэнэ.
44. Нэг хүнд олон үүрэг давхардуулан оноохгүй байх зарчмыг баримтална.
45. Хүний эрхийн тодорхой асуудал болон тодорхой улсын асуудлаарх тусгай үүрэг гүйцэтгэгч байхаас үл хамааран бүх тусгай үүрэг гүйцэтгэгчийн ажиллах хугацаа нь 6 жилээс дээшгүй байна. (Хүний эрхийн тодорхой асуудлаархи тусгай үүрэг гүйцэтгэгч нь 3 жилээр 2 удаа томилогдон ажиллаж болно.)
46. Засгийн газарт шийдвэр гаргах түвшний албан тушаал эрхэлдэг эсвэл тусгай үүрэг гүйцэтгэгчийн үүрэгт ажилтай нь уялдсан ашиг сонирхлын зөрчил үүсгэж болохуйц байгууллага, аж ахуйн нэгжид албан тушаал эрхэлдэг этгээд тусгай үүрэг гүйцэтгэгч байж болохгүй. Тусгай үүрэг гүйцэтгэгч нь өөрийн чадавхид тулгуурлан ажиллах үүрэгтэй.
47. Тухайн салбарт тавигдах ерөнхий шалгуур, тусгай шаардлагуудыг хамгийн өндөр түвшинд хангаж байгаа нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг Зөвлөлийн Ерөнхийлөгчид танилцуулах Зөвлөх бүлэг тусгай үүрэг гүйцэтгэгчдийг сонгох Зөвлөлийн хуралдаан болохоос 1-ээс доошгүй сарын өмнө байгуулагдсан байна.
48. Зөвлөх бүлэг нь нэр дэвшигчийг нэрсийн жагсаалтаас хасах асуудлыг хэлэлцэнэ.
49. Зөвлөлийн үйл ажиллагааны жилийн мөчлөг бүрийн эхэнд Бүс нутгийн бүлгүүд нь Зөвлөх бүлгийн гишүүнээ томилох бөгөөд гишүүнээр сонгогдсон хүн нь хувийн чадавхид тулгуурлан ажиллана. Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар нь Зөвлөх бүлэгт туслалцаа үзүүлэн ажиллана.
50. Зөвлөх бүлэг нь тухайн албан тушаалын тусгай шаардлага болон бусад нэмэлт нөхцөл байдлаас хамааран нэмэлт шалгаруулалт явуулахаас бусад тохиолдолд нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтад нэр дэвшигчдээс сонголт хийнэ. Зөвлөх бүлгээс Ерөнхийлөгчид хандан гаргасан зөвлөмж нь олон нийтэд нээлттэй байна.
51. Зөвлөх бүлэг нь тусгай үүрэг гүйцэтгэгч тус бүрийн онцлогт тохирсон ажлын арга барил, мэргэшил, туршлага, бусад шаардлагуудыг тодорхойлохдоо өмнө

- ажиллаж байсан болон одоо ажиллаж байгаа тусгай үүрэг гүйцэтгэгч зэрэг холбогдох талуудаас гаргасан санал, дүгнэлтийг аль болох харгалзан үзнэ.
52. Ерөнхийлөгч нь Зөвлөх бүлгийн зөвлөмжид үндэслэн Бүсийн бүлгүүд болон бусад талуудтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр тусгай үүрэг гүйцэтгэгчдийн орон тоо тус бүрд тохирох нэр дэвшигчийг тодорхойлно. Ерөнхийлөгч нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг тусгай үүрэг гүйцэтгэгчдийг томилох Зөвлөлийн хуралдаанаас 2 долоо хоногоос доошгүй хугацааны өмнө Зөвлөлийн гишүүд болон ажиглагч улсуудад мэдээлнэ.
53. Шаардлагатай бол Ерөнхийлөгч нь санал болгосон нэр дэвшигчийн талаар дэмжлэг авахын тулд дахин хэлэлцүүлэг явуулж болно. Нэр дэвшигчийг Зөвлөлөөр батласнаар томилогдсонд тооцно.

Б. Тусгай үүрэг гүйцэтгэгчдийн ажлыг дүгнэх, боловсронгуй болгох, сайжруулах

54. Тусгай үүрэг гүйцэтгэгчдийн ажил үүргийг дүгнэн боловсронгуй болгох, сайжруулах, түүнчлэн шинээр тусгай үүрэг гүйцэтгэгч бий болгох асуудал нь иргэний болон улс төрийн эрх, эдийн засаг, нийгэм, соёлын эрх болон хөгжих эрх зэрэг хүний эрхийг хангах хамгаалах шаардлагын үүднээс хүний эрхийн түгээмэл байдал, шударга ёс, олон улсын харилцаа, хамтын ажиллагаанд тулгуурлах, аль нэг улсыг онцлон буруушаахгүй байх, үнэн бодит байх зэрэг зарчмуудын хүрээнд явагдана.
55. Тусгай үүрэг гүйцэтгэгчдийн ажил үүргийг дүгнэн боловсронгуй болгох, сайжруулах ажил нь энэ тухай тогтоолыг зөвшилцөн батласан үеэс эхлэн хэрэгжинэ. Зөвлөл болон тусгай үүрэг гүйцэтгэгч нар тусгай үүрэг гүйцэтгэгчдийн ажил хэргийг үнэлэх талаар тусгайлан уулзалт хийж болно.
56. Тусгай үүрэг гүйцэтгэгчдийн ажил үүргийг дүгнэн боловсронгуй болгох, сайжруулах асуудал нь Ерөнхий Ассемблейн 60/251 тоот тогтоол болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийн хэм хэмжээний хүрээнд тухайн тусгай үүрэг гүйцэтгэгчид хамаарах хүний эрхийн асуудлууд, түүний эрх хэмжээ, агуулгад төвлөрнө.
57. Тусгай үүрэг гүйцэтгэгчийн эрх, үүргийг дуусгавар болгох, нэгтгэх, хязгаарлахтай холбоотой аливаа шийдвэр нь ямагт хүний эрхийг хангах, хамгаалах явдлыг сайжруулах шаардлагын үндсэн дээр гарна.
58. Зөвлөл нь нөхцөл байдлыг сайжруулахыг байнга эрмэлзэнэ:
- (а) Тусгай үүрэг гүйцэтгэгчид нь ямагт хүний эрхийн хангах хамгаалах явдлыг сайжруулах талаар тодорхой зорилготой байх төдийгүй хүний эрхийн бусад тогтолцоотой уялдсан байна.
 - (б) Хүний эрхийн бүх асуудалд адил тэгш анхаарал хандуулна. Хүний эрхийн тодорхой асуудлуудад адил тэгш ач холбогдол өгөх нь иргэний болон улс төрийн эрх, эдийн засаг, нийгэм, соёлын эрх түүнчлэн хөгжих эрхүүдэд адил тэгш ач холбогдол өгөх явдалтай нягт уялдсан байвал зохино.
 - (в) Шаардлагагүй давхардал үүсгэхээс ямагт татгалзана.
 - (г) Тусгай үүрэг гүйцэтгэгчдийн аль нэгэнд хамаарахгүй хүний эрхийн асуудлуудыг шийдвэрлэхэд шинээр орон тоо үүсгэхээс илүүтэйгээр тусгай үүрэг гүйцэтгэгч нар хамтарсан ажиллагаа явуулах, хэд хэдэн тусгай үүрэг гүйцэтгэгчид хамаарах асуудалд тэдгээрийн анхаарлыг хандуулах, одоо байгаа тусгай үүрэг гүйцэтгэгчдийн эрх хэмжээний хамрах хүрээг өргөтгөх хэлбэрээр шийдвэрлэнэ.

(д) Тусгай үүрэг гүйцэтгэгчдийн орон тоог нэгтгэх асуудлыг тухайн тусгай үүрэг гүйцэтгэгчийн зонхилох үүрэг, хамаарах асуудлууд түүнчлэн тухайн тусгай үүрэг гүйцэтгэгчийн ажлын ачаалал зэргээс шалтгаалан хэлэлцэнэ.

(е) Шинээр тусгай үүрэг гүйцэтгэгчийн орон тоо бий болгох болон тусгай үүрэг гүйцэтгэгчийн ажил хэргийг дүгнэхдээ чухам аль механизм нь хүний эрхийн хамгаалалтыг сайжруулахад илүү үр дүнтэй байгааг анхаарна. (Тусгай шинжээч, тусгай илтгэгч, ажлын хэсэг гэх мэт)

(ё) Шинээр тусгай үүрэг гүйцэтгэгчийн орон тоо бий болгох явдал нь хоёрдмол байдал үүсгэхээс сэргийлсэн аль болох оновчтой байвал зохино.

59. Тусгай үүрэг гүйцэтгэгчдийн тогтолцоог ойлгомжтой байлгах үүднээс тусгай үүрэг гүйцэтгэгчийн орон тоог нэрлэх болон нэрийг хэрэглэх, тэднийг сонгох, томилох талаар нийтлэг журам тогтоож болно.
60. Хүний эрхийн тодорхой асуудлаархи тусгай үүрэг гүйцэтгэгч нь 3 жил, тодорхой улс орны асуудлаархи тусгай үүрэг гүйцэтгэгч нь 1 жилийн хугацаагаар тус тус ажиллана.
61. Тусгай үүрэг гүйцэтгэгчдийг Хавсралт 1-ээс харж болох ба энэхүү орон тоо нь Зөвлөлийн үйл ажиллагааны ажлын хөтөлбөрөөс хамааран Зөвлөлөөр хэлэлцэгдэх хүртлээ хүчинтэй байна.
62. 6 жилээс хэтрэхгүй хугацаагаар ажиллаж байгаа одоогийн тусгай үүрэг гүйцэтгэгчид нь үргэлжлүүлэн ажиллана. Онцгой тохиолдолд 6 жилээс илүү хугацаагаар ажилласан тусгай үүрэг гүйцэтгэгчид нь Зөвлөлөөс дараагийн тусгай үүрэг гүйцэтгэгчийг сонгох, томилох хүртэл үргэлжлүүлэн ажиллаж болно.
63. Гишүүн улсуудын хүний эрхийн үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх чадавхийг дээшлүүлэх үүднээс шинээр тусгай үүрэг гүйцэтгэгчийн орон тоо бий болгох, зогсоох, ажил хэргийг нь дүгнэх, боловсронгуй болгох асуудал нь хамтын ажиллагаа, харилцан ойлголцох зарчмаар явагдахад анхаарна.
64. Зөвлөлийн анхаарлын төвд байгаа хүний эрхийн зөрчил, хамтын ажиллагааны хангалтгүй байдлыг хэлэлцэхэд тэгш хандах, урьдчилан сонгохгүй байх, үнэн бодит байх зарчмуудыг баримтлана.

III. ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨХ ХОРОО

65. Зөвлөлийн үйл ажиллагааны бодлого, чиглэлийг тодорхойлох үүрэг бүхий Зөвлөлийн Зөвлөх Хороо нь (*үүнээс хойш зөвлөх хороо гэнэ*) өөрийн итгэл үнэмшлийн үндсэн дээр ажиллах 18 шинжээчдээс бүрдэнэ. Энэхүү бие даасан салбар бүтцийг байгуулах, үүрэг хариуцлагыг нь тодорхойлоход дараахь журмыг баримтлана.

А. Нэр дэвшүүлэх

66. НҮБ-ын бүх гишүүд өөрийн газар зүйн бүсээсээ Зөвлөх хороонд нэр дэвшүүлэх буюу нэр дэвшигчийг дэмжиж болно. Улсууд нэр дэвшигчийг сонгохдоо өөрийн орны хүний эрхийн үндэсний байгууллага болон иргэний нийгмийн байгууллагуудтай зөвшилцөх бөгөөд нэр дэвшигчийг дэмжсэн байгууллагуудын нэрийг оруулна.
67. Хамгийн шилдэг шинжээчдийг сонгох үүднээс Зөвлөл нь 6-р хурлаараа (2 дахь мөчлөгийн эхний хуралдаан) Зөвлөх хороонд нэр дэвшигчдэд тавигдах техникийн болон бодит шаардлагуудыг хэлэлцэн батлана. Үүнд:
 - (а) Хүний эрх салбарт мэдлэг, туршлагаараа танигдсан байдал

- (б) Ёс зүйн өндөр түвшинтэй
- (в) Хараат бус, шударга байдал

68. Засгийн газарт шийдвэр гаргах түвшний албан тушаал эрхэлдэг эсвэл ашиг сонирхлын зөрчил үүсгэж болохуйц бусад байгууллага, аж ахуйн нэгжид ажилладаг хүмүүс Зөвлөх хороонд нэр дэвшиж болохгүй. Хорооны гишүүнээр сонгогдсон хүмүүс нь өөрийн итгэл үнэмшлийн үндсэн дээр ажиллана.
69. Нэгэн зэрэг олон үүрэг давхардуулан оноохгүй байх зарчмыг баримтлана.

Б. Сонгууль

70. Зөвлөл нь шаардлагад нийцсэн нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтаас нууц санал хураалт явуулж Зөвлөх хорооны гишүүдийг сонгоно.
71. Сонгууль явагдах өдрөөс 2 сарын өмнө нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт хаагдана. Нарийн бичгийн дарга нарын газар нь сонгууль явагдахаас 1 сараас доошгүй хугацааны өмнө нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт ба бусад холбогдох мэдээллүүдийг бэлтгэж гишүүн улсуудад болон олон нийтэд мэдээлнэ.
72. Эрх зүйн өөр өөр тогтолцоо, иргэншил болон хүйсийн тэнцвэрт байдлыг анхаарч үзнэ.
73. Газар зүйн тэнцвэрт байдлыг дараахь байдлаар хангана:
- Африкын улсуудаас 5
 - Азийн улсуудаас 5
 - Зүүн Европын улсуудаас 2
 - Латин Америк, Карибын улсуудаас 3
 - Баруун Европ болон бусад улсуудаас 3
74. Зөвлөх хорооны гишүүд нь 3 жилийн хугацаагаар сонгогдох бөгөөд дахин нэг удаа сонгогдох эрхтэй. Эхний удаа гишүүдийн гуравны нэг нь 1 жилийн хугацаагаар, мөн гуравны нэг нь 2 жилийн хугацаагаар сонгогдоно. Гишүүдийн сонгогдох хугацааны талаар эргэлзээ гарвал шодох аргаар шийдвэрлэнэ.

В. Үйл ажиллагаа

75. Судалгаа шинжилгээний ажилд төвлөрөн судалгааны үндсэн дээр Зөвлөлийн хүсэлтийн дагуу арга зүйн зөвлөмж өгөх нь Зөвлөх хорооны үндсэн чиг үүрэг байна.
76. Зөвлөх хорооны зөвлөмж нь хэрэгжих боломжтой байх бөгөөд хүний эрхийг хангах, хамгаалах Зөвлөлийн эрх хэмжээний хүрээн дэх асуудлаар хзгаарлагдана.
77. Зөвлөх хороо нь ямар нэгэн шийдвэр, тогтоол гаргахгүй. Зөвлөлөөс тогтоосон хүрээнд түүний үйл ажиллагааны үр дүнг цаашид сайжруулах, түүнчлэн цаашдын судалгааны чиглэлийн талаар санал боловсруулж, Зөвлөлд батлуулахаар хүргүүлнэ.
78. Зөвлөл нь Зөвлөх хорооны санал дүгнэлтийг хэрхэн авах талаар тусгай журам гаргах бөгөөд тухайн зөвлөмжийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь боловсронгуй болгох шаардлагатай бол нэмэлт өөрчлөлт оруулж болно.

Г. Үйл ажиллагааны журам

79. Зөвлөх хороо нь нэг жилд ажлын 10 хоногоос илүүгүй хугацаагаар 2 удаа хуралдана. Тухайн нөхцөл байдлаас хамааран Зөвлөлийн зөвшөөрснөөр нэмэлт хуралдаан хийж болно.

80. Зөвлөл нь тодорхой асуудлыг хэсэгчилсэн баг юмуу ганцаарчлан гүйцэтгүүлэхээр Зөвлөх хороонд даалгаж болно. Зөвлөх хороо нь энэхүү үүрэг даалгаврын талаар Зөвлөлд тайлагнана.
81. Хэдийгээр Зөвлөх хороо нь Зөвлөл зөвшөөрснөөс бусад тохиолдолд бие даасан байгууллага байгуулж болохгүй боловч Зөвлөх хорооны гишүүд хуралдааны чөлөөт цагт багаар буюу гарцаарчлан ажиллах боломжоор хангагдана.
82. Зөвлөх хороо нь өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа Зөвлөлийн үйл ажиллагааны журмын дагуу улсуудын Засгийн газар, хүний эрхийн үндэсний байгууллагууд, төрийн бус болон иргэний нийгмийн байгууллагуудтай харилцана.
83. Зөвлөх хорооны үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх үүднээс Эдийн засаг, Нийгмийн Зөвлөлийн 1996/31 тоот тогтоол, Хүний эрхийн зөвлөл, Хүний эрхийн хорооны тогтсон практикийн хүрээнд Зөвлөлийн гишүүн болон ажиглагч улсууд, түүний дотор Зөвлөлийн гишүүн бус орнууд, хүний эрхийн үндэсний байгууллагууд, түүнчлэн төрийн бус байгууллагууд Зөвлөх хорооны үйл ажиллагаанд оролцож болно.
84. Зөвлөл нь 6-р хурлаараа (2-р мөчлөгийн 1-р хуралдаан) уугуул иргэдийн болон орчин үеийн боолчлолын хэлбэр, цөөнхийн асуудал, нийгмийн хэлэлцүүлгийн (social forum) асуудлаархи Ажлын хэсгүүдийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх зохистой арга хэрэгслийг хэлэлцэн батлана.

IV. ГОМДОЛ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

А. Зорилго, үйлчлэх хүрээ

85. Дэлхийн хаана ч, ямар ч нөхцөлд гарч байгаа хүний үндсэн эрх, эрх чөлөөний ноцтой зөрчлийг арилгахын тулд гомдол хянан шийдвэрлэх тогтолцоог байгуулав.
86. 2000 оны 6 сарын 19-ний өдрийн 2000/3 тоот тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон Эдийн засаг, Нийгмийн Зөвлөлийн 1970 оны 5 сарын 27 ны өдрийн 1503 (XLVIII) тогтоолд гомдол гаргах журам нь цаг хугацааны хувьд оновчтой, хохирогчийг хамгаалахад чиглэсэн, үр дүнтэй, бодитой, шударга байдлыг хангах эрх зүйн үндэс болно гэж заасан. Гомдолд хамаарах Улстай хамтран ажиллах үүднээс гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагаа нь нууцыг хадгалах байдлаар явагдана.

Б. Гомдолд тавигдах шаардлага

87. Энэхүү журмын дагуу шийдвэрлэгдэх гомдол, мэдээлэл нь дараахь шаардлагуудыг хангасан байна:
- (а) Гомдол нь илэрхий улс төрийн агуулгагүй байх бөгөөд НҮБ-ын дүрэм, Хүний эрхийн тунхаглал болон хүний эрхийн бусад хэм хэмжээгээр баталгаажсан хүний эрхийг зөрчсөн тухай байх
 - (б) Зөрчигдөж байгаа гэх эрхүүд болон түүнийг хэрхэн зөрчсөн талаар тодорхой баримттай мэдээлсэн байх
 - (в) Бүдүүлэг үг хэллэг хэрэглээгүй байх. Бүдүүлэг үг хэллэгийг арилгасны дараа гомдол нь бусад шаардлагуудад нийцсэн хэвээр байвал уг гомдлыг авч хэлэлцэж болно.

(г) Эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэх нэг буюу хэсэг бүлэг хүмүүс гомдол гаргах эрхтэй ба хүний эрх, эрх чөлөөний талаар үнэн бодит шууд мэдээлэл бүхий бусад этгээд буюу хэсэг бүлэг хүмүүс, төрийн бус байгууллага нь НҮБ-ын Дүрэмд харш улс төрийн сэдэлгүй бол бусдын зөрчигдсөн эрх, эрх чөлөөний талаар гомдол гаргаж болно. Гомдолд дурдсан мэдээлэл нь дам мэдээлэл боловч хангалттай нотлох баримтуудаар нотлогдож байвал түүнийг хянан хэлэлцэхээс татгалзах үндэслэл болохгүй.

(д) хэвлэл мэдээлэлд нийтлэгдсэн мэдээлэлд үндэслээгүй байх

(е) Тухайн зөрчил нь өмнө нь НҮБ-ын тусгай хэрэгслүүд, гэрээний хороод, НҮБ-ын бусад байгууллага, тэдгээртэй төсөөтэй бүсийн хүний эрхийн байгууллагуудаар хэлэлцэгдээгүй байх

(ё) Үр дүн муутай эсвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удааширнаас тохиолдолд тухайн орны дотоодын хүний эрхийг хамгаалах механизмуудыг гүйцээсэн байх

88. Хүний эрхийн үндэсний байгууллагуудын эрх зүйн байдлын тухай зарчмууд (Парисын зарчмууд)-ын үндсэн дээр байгуулагдсан хүний эрхийн үндэсний байгууллагууд нь гомдол хянан шалгах эрх хэмжээтэй тул хүний эрхийн зөрчлийг үндэсний хэмжээнд үр дүнтэй шийдвэрлэх хэрэгсэл мөн.

В. Ажлын хэсгүүд

89. Хүний үндсэн эрх, эрх чөлөөний ноцтой зөрчлүүдэд Зөвлөлийн анхаарлыг хандуулах, гомдлыг хянан үзэх үүрэг бүхий 2 тусгай ажлын хэсэг байгуулагдан ажиллана.

90. Дээрх 2 ажлын хэсгүүд нь зөвшилцлийн үндсэн дээр үйл ажиллагаагаа аль болох өргөн хүрээнд явуулна. Зөвшилцөлд хүрч чадаагүй бол асуудлыг энгийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Ажлын хэсгүүд нь үйл ажиллагааны журмаа өөрсдөө тогтооно.

1. Гомдол хүлээн авах ажлын хэсэг: Бүрэлдэхүүн, гишүүдийг томилох, эрх, үүрэг

91. ХЭЗ-ийн Зөвлөх хороо нь Гомдол хүлээн авах ажлын хэсгийн 5 гишүүдийг өөрийн гишүүдийн дотроос сонгоно. Ингэхдээ хүйсийн тэнцвэрт байдал болон бүс нутгийн бүлэг тус бүрийн төлөөллийг хангах байдлыг харгалзана.

92. Сул орон тоо гарсан тохиолдолд Зөвлөх хорооны гишүүд дотроос өндөр мэргэшил чадвар бүхий, хараат бусаар ажиллах хүнийг өмнөх гишүүний хамаарах газар зүйн бүсээс сонгоно.

93. Гомдол хүлээн авч, мэргэжлийн өндөр түвшинд хянан шалгах, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах үүднээс Гомдол хүлээн авах Ажлын хэсгийн гишүүнийг 3 жилийн хугацаагаар томилно. Гишүүд зөвхөн нэг удаа улиран сонгогдож болно.

94. Гомдол хүлээн авах Ажлын хэсгийн ахлагч нь гомдлын талаарх мэдээллийг холбогдох улсад илгээхээс өмнө гомдол хүлээн авахаас татгалзах үндэслэл байгаа эсэхийг дангаараа эсвэл ажлын албатай хамтран хянаж үзнэ.

Шалгалтаар гомдол хүлээн авахаас татгалзах үндэслэл илэрсэн болон нэргүй гомдол байвал тухайн гомдлын тухай мэдээллийг холбогдох улсад илгээхгүй. Хариуцлага ил тод байдлыг хангах үүднээс Ажлын хэсгийн ахлагч нь анхан шатны хянан шалгалтаар хэрэгсэхгүй болгогдсон гомдлуудын жагсаалт болон холбогдох бусад мэдээллүүдийг ажлын хэсгийн бусад гишүүдэд хүргүүлнэ. Гомдол хүлээн авахаас татгалзах тухай шийдвэр гаргах үндэслэлийг энэхүү жагсаалтад дурьдсан байна. Анхан шатны шалгалт хийсний дараа хариу тайлбар, санал дүгнэлт авах зорилгоор хүний эрхийн тухайн зөрчлийн талаархи бусад мэдээллийг холбогдох улсуудад хүргүүлнэ.

95. Гомдол хүлээн авах ажлын хэсгийн гишүүд нь гомдлыг хүлээн авах, хянан хэлэлцэхээс татгалзах үндэслэл байгаа эсэхийг тогтоохоос гадна хүний эрхийн ноцтой, ужиг зөрчлийг илрүүлэн гаргахын тулд тухайн асуудалтай холбоотой өөр гомдлууд байгаа эсэхийг мөн шалган тогтооно. Гомдол хүлээн авах ажлын хэсэг нь шаардлага хангасан гомдол мэдээллүүдийг өөрийн зөвлөмжийн хамт Гомдлыг хянан шийдвэрлэх ажлын хэсэгт шилжүүлнэ. Тухайн хэргийн талаар нэмэлт мэдээлэл шаардлагатай болон түүнийг дахин хянан шалгах шаардлагатай бол дараагийнхаа хуралдааныг хүртэл болон холбогдох улсаас хариу тайлбар ирэх хүртэл шилжүүлэхгүй байж болно. Гомдол хүлээн авах ажлын хэсэг нь гомдлыг хэрэгсэхгүй болгох тухай шийдвэр гаргаж болно. Гомдол хүлээн авах ажлын хэсгийн бүх шийдвэрүүд нь нарийн шалгуур, зохих тайлбаруудаар нотлогдсон байх ёстой.

2. Гомдол хянан шалгах ажлын хэсэг: Бүрэлдэхүүн, гишүүдийг томилох, эрх, үүрэг

96. Бүс нутгийн бүлэг тус бүр нь өөрийн бүлэгт хамаарах Зөвлөлийн гишүүд дундаас нэг хүнийг Гомдол хянан шалгах ажлын хэсгийн гишүүнээр томилно. Ингэхдээ хүйсийн тэгш байдлыг харгалзан үзнэ. Ажлын хэсгийн гишүүд нь нэг жилийн хугацаагаар томилогдох бөгөөд тухайн улс нь Зөвлөлийн гишүүн байх тохиолдолд дахин нэг удаа улиран ажиллаж болно.
97. Гомдол хянан шалгах ажлын хэсгийн гишүүн нь өөрийн итгэл үнэмшил дээр тулгуурлан ажиллана. Ажлын хэсгийн гишүүний орон гарсан тохиолдолд түүний хамаарах бүс нутгийн бүлгээс дараагийн гишүүнийг томилно.
98. Гомдол хянан хэлэлцэх ажлын хэсэг нь Гомдол хүлээн авах ажлын хэсгээс ирүүлсэн мэдээлэл, зөвлөмжинд тулгуурлан хүний эрх, эрх чөлөөний ужиг, ноцтой бөгөөд нотлогдсон зөрчлийн талаар илтгэл бэлтгэж Зөвлөлд өгнө. Мөн Хүний эрхийн зөрчил түүнд авбал зохих арга хэмжээний талаар зөвлөмжийг гарган тогтоол, шийдвэрийн хэлбэрээр бэлтгэн Зөвлөлд танилцуулж хэлэлцүүлнэ. Тухайн гомдлын талаар нэмэлт мэдээлэл шаардлагатай болон дахин хянан хэлэлцэх шаардлагатай тохиолдолд асуудлыг дараагийн хуралдаан хүртэл хянан үзэж болно. Гомдол хянан хэлэлцэх ажлын хэсэг нь гомдлыг хэрэгсэхгүй болгох эрхтэй.
99. Хорооны бүх шийдвэр нь тухайн асуудлыг нарийвчлан хэлэлцсэний үндсэн дээр гарах бөгөөд гомдлыг хэрэгсэхгүй болгосон болон цаашид авах арга хэмжээний тухай зөвлөмж гарах болсон үндэслэл шалтгаанаа тодорхойлсон байна. Гомдлыг хэрэгжсэхгүй болгох шийдвэрийг зөвшилцлөөр шийдэх бөгөөд зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд энгийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

Г. Ажиллах журам, нууцыг хадгалах

100. Гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа нь хохирогчийг хамгаалахад чиглэсэн бөгөөд нууцыг хадгалж, цаг алдалгүй явагдах ёстой тул хүлээн авсан гомдлууд болон холбогдох улсуудын хариу тайлбарыг бүх талаас нь бүрэн дүүрэн хянан шалгахын тулд дээрх 2 Ажлын хэсэг нь жилд хоёроос доошгүй удаа ажлын 5 өдөр хуралдана.
101. Гомдолд холбогдох улс нь Гомдол хянан хэлэлцэх ажлын хэсгээс ирүүлсэн бүх шаардлагуудад хүсэлтийг хүлээн авсанаас хойш 3 сарын дотор, НҮБ-ын албан ёсны аль нэг хэлээр бүрэн дүүрэн, хангалттай хариулт өгөх ба гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцон хамтран ажиллах талаар шаардлагатай бүх арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй. Тухайн улсын хүсэлтээр энэ хугацааг сунгаж болно.
102. Хэргийг хангалттай судлан үзэх боломж бүрдүүлэх үүднээс Ажлын алба нь хэрэгт холбогдолтой баримт бичгүүдийг эмхэтгэн хоёр долоо хоногоос доошгүй хугацааны өмнө Зөвлөлийн гишүүдэд хүргүүлнэ.
103. Зөвлөл нь Гомдол хянан хэлэлцэх Ажлын хэсгийн шаардсаны дагуу хүний эрхийн ужиг, ноцтой, нотлогдсон зөрчлүүдийг жилд нэгээс доошгүй удаа буюу аль болох олон удаа хэлэлцэн шийдвэрлэнэ.
104. Зөвлөл өөрөөр шийдвэрлэснээс бусад тохиолдолд Гомдол хянан хэлэлцэх Ажлын хэсгээс ирүүлсэн тайланг хаалттай хэлэлцэнэ. Онцгой нөхцөл байдал болсон эсвэл гомдолд холбогдох улс удаа дараа хамтран ажиллахаас татгалзсан үндэслэлээр Гомдол хянан хэлэлцэх Ажлын хэсгээс уг асуудлыг олон нийтэд нээлттэй байдлаар хянан хэлэлцэхээр Зөвлөлд санал оруулж болно. Энэ тохиолдолд Зөвлөл уг асуудлыг дараагийн хуралдаанаараа нэн тэргүүнд шийдвэрлэнэ.
105. Гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа нь хохирогчийг хамгаалахад чиглэсэн, цаг алдалгүй, үр дүнтэй явагдах ёстой тул гомдлын тухай мэдээллийг холбогдох улсад хүргүүлснээс хойш 24-өөс дээшгүй сарын дотор Зөвлөл хэргийг хянан хэлэлцэнэ.

Д. Гомдол хянан шийдвэрлэх ажиллагаан дахь гомдол гаргагч болон гомдолд холбогдох улсын оролцоо

106. Гомдол хянан шийдвэрлэх дараахь үндсэн ажиллагаануудын талаар гомдол гаргагч болон гомдолд холбогдох улсуудад мэдэгдэнэ:
- (а) Гомдол хүлээн авах Ажлын хэсгээс гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай шийдвэрлэсэн, Гомдол хянан хэлэлцэх ажлын хэсэг гомдлыг хянан үзэж байгаа болон гомдол нь аль нэг ажлын хэсэг юмуу Зөвлөл дээр хүлээгдэж байгаа бол
- (б) Гомдлын тухай эцсийн шийдвэр гарсан
107. Гомдлыг бүртгэн хүлээн авсан талаар гомдол гаргагчид мэдэгдэнэ.
108. Гомдол гаргагч өөрийн нэр, хаягийг нууцлахыг хүссэн бол түүний нэр, хаягийг гомдолд холбогдох улсад мэдэгдэхгүй.

Е. Авах арга хэмжээ

109. Тухайн нөхцөл байдлаас шалтгаалан дараахь арга хэмжээнүүдийн аль нэгийг авна:
- (а) Хэргийг цаашид хэлэлцэх арга хэмжээ авах шаардлагагүй бол хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоох

- (б) Асуудлыг анхааралдаа байлгаж, гомдолд холбогдох улсаас нэмэлт мэдээлэл ирүүлэхийг шаардан гомдол хянан шийдвэрлэх ажиллагааг тодорхой хугацаагаар сунгах
- (в) Хэргийг судлан Зөвлөлд тайлагнах үүрэг бүхий өндөр мэргэшсэн, бие даасан шинжээчийг томилон гомдол хянан шийдвэрлэх ажиллагааг сунгах
- (г) Гомдлыг олон нийтэд ил тод хэлэлцэх үүнээс хаалттай хэлэлцэхээс татгалзах
- (д) Гомдолд холбогдох улсад техникийн болон чадавхийг дээшлүүлэх, арга зүйн бусад туслалцаа үзүүлэхийг Хүний эрхийн дээд комиссарын газраас хүсэх

V. ЗӨВЛӨЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

A. Үйл ажиллагааны зарчим

Түгээмэл байдал
 Шударга байдал
 Чиглэл зорилготой, бодитой байх
 Урьдчилан сонгохгүй байх
 Харилцан ойлголцол, ажил хэрэгч хамтын ажиллагаа
 Тодорхой, ойлгомжтой байх
 Уян хатан байх
 Ил тод байх
 Хариуцлагатай байх
 Тэнцвэртэй байх
 Хүртээмжтэй, олон талыг хамарсан байх
 Хүйсийн тэгш байдлыг хүндэтгэх
 Шийдвэрүүдийн хэрэгжилт болон хэрэгжүүлэх ажлууд хийх

Б. Хөтөлбөр

- Хэлэлцэх асуудал 1. Дотоод зохион байгуулалт, дэг журмын асуудал
- Хэлэлцэх асуудал 2. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга болон Хүний эрхийн дээд комиссар, түүний ажлын албаны жилийн тайлан хэлэлцэх
- Хэлэлцэх асуудал 3. Хүний бүх эрх, иргэний болон улс төрийн эрх, эдийн засаг, нийгэм, соёлын болон хөгжих эрхийг хангах, хамгаалахтай холбоотой асуудал
- Хэлэлцэх асуудал 4. Зөвлөлийн анхаарлыг татсан хүний эрхийн нөхцөл байдал
- Хэлэлцэх асуудал 5. Хүний эрхийн байгууллагууд болон механизмууд
- Хэлэлцэх асуудал 6. Хүний эрхийн ерөнхий төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг
- Хэлэлцэх асуудал 7. Палестин болон Арабын бусад эзлэгдсэн газар нутаг дахь хүний эрхийн нөхцөл байдал
- Хэлэлцэх асуудал 8. Вений тунхаглал, үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт ба хэрэгжүүлэхээр авч буй арга хэмжээнүүд
- Хэлэлцэх асуудал 9. Арьсны үзэл болон бусдыг үзэн ядах, арьс өнгө бусад хэлбэрээр ялгаварлан гадуурхахтай холбоотой асуудлыг хэлэлцэх. Дурбаны тунхаглал болон үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, хэрэгжилтийг хангах арга хэмжээ
- Хэлэлцэх асуудал 10. Техникийн тусламж болон чадавхийг бэхжүүлэх асуудал

B. Үйл ажиллагааны хөтөлбөрийн хамрах хүрээ

Хэлэлцэх асуудал 1. Дотоод зохион байгуулалт, дэг журмын асуудал

Товчоог сонгох
Жилийн ажлын төлөвлөгөөг батлах
Хуралдааны болон бусад ажил хэргийн хөтөлбөрийг батлах
Тусгай хэрэгслийн үүрэг гүйцэтгэгчдийг томилох
Хүний эрхийн Зөвлөлийн Зөвлөх хорооны гишүүдийг сонгох
Хуралдааны илтгэлийг батлах
Зөвлөлийн жилийн тайланг батлах

Хэлэлцэх асуудал 2. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга болон Хүний эрхийн дээд комиссар, түүний ажлын албаны жилийн тайланг хэлэлцэх

Тайлан түүнд орсон өөрчлөлтийг танилцуулах илтгэл

Хэлэлцэх асуудал 3. Хүний бүх эрх, иргэний болон улс төрийн эрх, эдийн засаг, нийгэм, соёлын болон хөгжих эрхийг хангах хамгаалахтай холбоотой асуудал

Эдийн засаг, нийгэм, соёлын эрх
Иргэний болон улс төрийн эрхүүд
Онцгой бүлэг ба хувь хүмүүсийн эрх
Хөгжих эрх
Хүний эрх ба хүний эрхийн тодорхой асуудлуудын хоорондын хамаарал

Хэлэлцэх асуудал 4. Зөвлөлийн анхаарлыг татсан хүний эрхийн нөхцөл байдал

Хэлэлцэх асуудал 5. Хүний эрхийн байгууллагууд болон механизмууд

Хүний эрхийн зөвлөлийн Зөвлөх хорооны илтгэл
Гомдол хянан шийдвэрлэлтийн талаарх илтгэл

Хэлэлцэх асуудал 6. Хүний эрхийн ерөнхий төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг

Хэлэлцэх асуудал 7. Палестин болон Арабын бусад эзлэгдсэн газар нутаг дахь хүний эрхийн нөхцөл байдал

Израилаас Палестин болон Арабын бусад нутаг дэвсгэрийг эзэлсэнтэй холбоотой хүний эрхийн нөхцөл байдал
Палестиний ард түмний өөртөө засан тогтнох эрх

Хэлэлцэх асуудал 8. Венийн тунхаглал, үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт ба хэрэгжүүлэхээр авч буй арга хэмжээнүүдийг хэлэлцэх

Хэлэлцэх асуудал 9. Арьсны үзэл болон бусдыг үзэн ядах, арьс өнгө бусад хэлбэрээр ялгаварлан гадуурхахтай холбоотой асуудлыг хэлэлцэх. Дурбаны тунхаглал болон үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, хэрэгжилтийг хангах арга хэмжээ

VI. АЖЛЫН АРГА БАРИЛ

110. Ерөнхий Ассемблейн 60/251 тоот тогтолд дурьдсанаар Зөвлөлийн үйл ажиллагааны арга барил нь ил тод, шударга байх, тэгш хандах, бодитой байх, прагматик болон талуудын оролцоог хангах, тодорхой ойлгомжтой байх, хүний эрхийн бүх асуудлыг хамрах зэрэг бөгөөд эдгээр нь цагийн аясаар өөрчлөгдөж, боловсронгуй болж болно.

А. Тогтолцооны зохион байгуулалт

1. Зөвлөлийн тогтоол, шийдвэрийн талаарх мэдээлэл

111. Хэлэлцэх асуудлын жагсаалтад орсон эсвэл орох гэж буй тогтоол, шийдвэрийн талаар төлөөлөгчид хүсвэл гэвэл тухайн тогтоол шийдвэрийн талаар мэдээлэл өгөх уулзалт хийнэ. Энэхүү уулзалтыг сонирхогч талууд өөрсдөө зохион байгуулна.

2. Тогтоол шийдвэр, бусад асуудлын талаарх Ерөнхийлөгчийн нээлттэй хэлэлцүүлэг

112. Зөвлөлийн тогтоол, шийдвэр, бусад асуудлын талаарх Ерөнхийлөгчийн нээлттэй хэлэлцүүлэг нь тухайн тогтоол шийдвэрийн талаарх хэлэлцээний явц байдал, талуудын байр суурийн талаарх мэдээллийг төлөөлөгчдөд өгнө. Энэхүү арга хэмжээ нь гагцхүү мэдээлэл өгөхөд чиглэгдэх бөгөөд ил тод, оролцоог хангах байдлаар зохион байгуулагдана. Харин тухайн асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэхгүй.

3. Тогтоол, шийдвэрийн төслийг санаачлагчдаас зохион байгуулах албан бус зөвлөгөөн

113. Тогтоолын төслийн талаарх хэлэлцээний гол арга нь албан бус зөвлөгөөн бөгөөд шийдвэр, тогтоолын төсөл дээр санал авах зорилгоор тухайн баримт бичгийг санаачлагчид албан бус зөвлөгөөн зохион байгуулж болно. Шийдвэр тогтоол бүрийг Зөвлөлөөр хэлэлцэн батлахаас өмнө дор хаяж нэгээс доошгүй удаа албан бус, нээлттэй хэлэлцүүлэг хийсэн байна. Төлөөлөгчид, ялангуяа жижиг бүлгүүдийн бэрхшээлийг шийдвэрлэхэд анхаарч, албан бус зөвлөгөөнийг аль болох ил тод, оролцоог хангасан байдлаар явуулах ёстой.

4. Товчооны үүрэг (bureau)

114. Товчоо нь зохион байгуулалт, дэг журмын асуудлыг хариуцна. Хуралдаан тус бүрийн хураангуй тайланг бэлтгэнэ.

5. Мэтгэлцээн, дугуй ширээний ярилцлага, семинар зэрэг үйл ажиллагааны бусад хэлбэрүүд

115. Мэтгэлцээн, дугуй ширээний ярилцлага, семинар зэрэг үйл ажиллагаа зохион байгуулах эсэхийг тухайн нөхцөл байдлаас хамааран Зөвлөл

шийдвэрлэнэ. Эдгээр нь аливаа асуудлын талаархи олон талын харилцан ойлголцлыг бий болгох, яриа хэлэлцээг өрнүүлэх зорилгоор хэрэглэгдэж болно. Зөвлөлийн ажлын төлөвлөгөө хөтөлбөрийн хүрээнд эсвэл засгийн газар хоорондын нэмэлт үйл ажиллагаа хэлбэрээр явагдаж болно. Гэхдээ нэгэнт бий болсон хүний эрхийн механизм, тогтсон ажлын арга хэлбэрийг орлох байдлаар хэрэглэгдэх ёсгүй.

6. Дээд хэмжээний уулзалт

116. Дээд хэмжээний уулзалт нь жилд нэг удаа Зөвлөлийн гол хуралцааны үеэр зохион байгуулагдана. Дээд хэмжээний уулзалтын дараа ерөнхий уулзалт явагдах бөгөөд дээд хэмжээний уулзалтад оролцоогүй төлөөлөгчид мэдэгдэл хийж болно.

Б. Үйл ажиллагааны хэв маяг

117. Дараахь байдлаар ажиллана:
- (а) Саналаа урьдчилан мэдэгдэх
 - (б) Хуралдааны сүүлчийн долоо хоног болохоос өмнө тогтоол, шийдвэрийн төслийг өргөн барих
 - (в) Төлөөлөгчдөд аль болох хурдан хүргэх үүднээс аливаа тайлан ялангуяа тусгай хэрэгслүүдийн тайланг Зөвлөлөөр хэлэлцэгдэхээс 15 хоногийн өмнө НҮБ-ын албан ёсны бүх хэлээр бэлтгэн хүргүүлсэн байх
 - (г) Аль нэг улсын асуудлаар тогтоол санаачлагч нь тухайн асуудлаар бусад улсуудаас аль болох өргөн дэмжлэг авсан байх (дор хаяж 15 улс дэмжсэн байх)
 - (д) Саналын төсөл өргөн барихад дараахь асуудлыг анхаарвал зохино:
 - (i) Ерөнхий Ассемблейн 3-р хорооны гаргаж байгаа санаачлагуудтай давхардахгүй байх
 - (ii) Хөтөлбөрийн дагуу хэлэлцэх асуудлуудтай уялдаа холбоотой байх
 - (iii) Хөтөлбөрийн дагуу хэлэлцэх асуудалтай холбоотой үйл ажиллагаа, тогтоол, шийдвэрийг тодорхой дэс дараатай хэлэлцэх (нэг дор бүгдийг хэлэлцэх албагүй)

Тогтоол, шийдвэрээс бусад баримт бичиг

118. Үүнд Ерөнхийлөгчийн мэдэгдэл, хуралдааны тэмдэглэл, зөвлөмж, дүгнэлт хамаарагдана. Эдгээр баримт бичиг нь тогтоол шийдвэрийг орлохгүй бөгөөд эрх зүйн үр дагавар нь ялгаатай байна.

Г. Зөвлөлийн тусгай хуралдаан

119. Дараахь зүйл заалтууд нь Ерөнхий ассемблейн 60/251 тоот тогтоол болон Зөвлөлийн үйл ажиллагааны журамд нэмэлт байдлаар хэрэглэгдэнэ.
120. Зөвлөлийн ээлжит хуралдааны журам нь тусгай хуралдаанд мөн адил хамаарна.
121. Ерөнхий Ассемблейн 60/251 тоот тогтоолын 10 дугаар зүйлд заасны дагуу тусгай хуралдаан явуулах тухай хүсэлийг Зөвлөлийн ажлын алба болон Ерөнхийлөгчид өргөн барина. Тусгай хуралдаан явуулах хүсэлт гаргагч нь

хэлэлцэх тодорхой асуудал болон холбогдох бусад бүх мэдээллийг хүсэлтдээ хавсаргасан байна.

122. Тусгай хуралдаан явуулахыг хүссэн албан ёсны хүсэлтийг хүлээн авсанаас хойш ажлын 2 хоногоос доошгүй, 5 хоногоос дээшгүй хугацааны дотор тусгай хуралдааныг зохион байгуулна. Зөвлөл өөрөөр шийдвэрлээгүй бол тусгай хуралдаан нь ажлын 3 хоногоос илүүгүй хугацаагаар үргэлжлэнэ.
123. Зөвлөлийн ажлын алба нь тусгай хуралдаан хийлгэх тухай хүсэлт болон санаачлагчаас ирүүлсэн бусад мэдээллүүд, түүнчлэн тусгай хуралдаан явагдах хугацааны талаар НҮБ-ын бүх гишүүн улсууд болон төрөлжсөн байгууллагууд, засгийн газар хоорондын бусад байгууллага, хүний эрхийн үндэсний байгууллагууд, зөвлөх статус бүхий төрийн бус байгууллагуудад аль болох хурдан бөгөөд зохистой арга хэлбэрээр мэдээлнэ. Тусгай хуралдаанаас гарах баримт бичиг, ялангуяа тогтоолын төслийг аль болох богино хугацааны дотор НҮБ-ын албан ёсны бүх хэлээр НҮБ-ын бүх гишүүн улсуудад нэгэн зэрэг, хурдан, ил тод хэлбэрээр хүргэнэ.
124. Ерөнхийлөгч нь тусгай хуралдааны зохион байгуулалт бусад асуудлын талаар мэдээллийн нээлттэй уулзалтыг тусгай хуралдаанаас өмнө зохион байгуулна. Иймд Ажлын алба нь өмнөх тусгай хуралдаануудын журмын талаар нэмэлт мэдээлэл өгөх үүрэгтэй.
125. Зөвлөлийн гишүүн улсууд болон тусгай хуралдаанд холбогдох улс, ажиглагч улсууд, НҮБ-ын төрөлжсөн болон хүний эрхийн үндэсний байгууллагууд, зөвлөх статус бүхий төрийн бус байгууллагууд нь Зөвлөлийн үйл ажиллагааны журмын дагуу тусгай хуралдаан дээр саналаа хэлж болно.
126. Хэрэв тусгай хуралдаан санаачлагч болон бусад улсуудаас тусгай хуралдааны үеэр тогтоол, шийдвэр өргөн барихыг хүсвэл Зөвлөлийн холбогдох дүрэм журмыг баримтлана. Тогтоол, шийдвэрийг санаачлагч нь төслийг аль болох эрт мэдээлэх үүрэгтэй.
127. Тухайн тогтоол шийдвэрийн төслийг хэлэлцэхэд аль болох олон улсыг оролцуулах, тохиролцоонд хүрэх үүднээс санаачлагч нь мэдээлэл хүргэх нээлттэй уулзалтыг зохион байгуулж болно.
128. Тусгай хуралдаан нь асуудлыг хэлэлцэхэд улсуудын өргөн оролцоог дэмжихсэн байдлаар явагдах бөгөөд бодит үр дүн бий болгоход чиглэсэн байна. Зөвлөл тусгай хуралдааны шийдвэрийн биелэлтэд хяналт тавих бөгөөд цаашид хийх үйл ажиллагааг тодорхойлохын тулд Зөвлөлийн дараагийн ээлжит хуралдаанаар хэлэлцэнэ.

VII. ХУРАЛДААНЫ ЖУРАМ

ЭЭЛЖИТ ХУРАЛДААНУУД

Хуралдааны журам

Журам 1. (60/251 тоот тогтоол, 11 дүгээр хэсэг)

Ерөнхий Ассемблей эсвэл Зөвлөл өөрөөр шийдвэрлээгүй бол Хүний эрхийн зөвлөл нь Ерөнхий Ассемблейн үндсэн хороодын үйл ажиллагааны журмыг даган мөрдөнө.

ЭЭЛЖИТ ХУРАЛДААН

Хуралдааны тоо

Журам 2. (60/251 тоот тогтоол, 10 дугаар хэсэг)

Зөвлөл нь жилд Заас доошгүй удаа 10 долоо хоногоос багагүй хугацаагаар хуралдана.
Гишүүн элсүүлэх

Журам 3

Зөвлөлийн тухайн жилийн хуралдааны эхний өдөр өмнөх гишүүдийн гишүүний хугацаа дуусгавар болж, шинээр сонгогдсон гишүүдийн хугацаа тоологдож эхлэнэ.

Хуралдаан явагдах газар

Журам 4 (60/251 тоот тогтоол, 1 дүгээр хэсэг)

Хүний эрхийн Зөвлөл нь Женевад байрлана.

ТУСГАЙ ХУРАЛДААН

Тусгай хуралдааныг явуулах

Журам 5

Хүний эрхийн Зөвлөлийн ээлжит хуралдааны журам нь тусгай хуралдаанд нэгэн адил хамаарна.

Журам 6 (60/251 тоот тогтоол, 10 дугаар хэсэг)

Тусгай хуралдаан хийх тухай Зөвлөлийн аль нэг гишүүний санаачлагыг бүх гишүүдийн гуравны нэг хувь нь дэмжсэн бол тусгай хуралдааныг явуулна.

ЗӨВЛӨЛИЙН АЖИГЛАГЧ УЛСУУДТАЙ ХАРИЛЦАХ БОЛОН ТЭДНИЙ ОРОЛЦОО

Журам 7 (60/251 тоот тогтоол, 11 дүгээр хэсэг)

(а) Ерөнхий Ассемблей болон Зөвлөл өөрөөр шийдвэрлээгүй бол Зөвлөл нь Ерөнхий Ассемблейн хороодын үйл ажиллагааны журмыг дагах бөгөөд ажиглагчид, Зөвлөлийн гишүүн бус улсууд, НҮБ-ийн төрөлжсөн байгууллагууд болон хүний эрхийн үндэсний байгууллагууд түүнчлэн төрийн бус байгууллагуудтай харилцах, зөвлөлийн үйл ажиллагаан дахь тэдгээрийн оролцоо нь Эдийн засаг, Нийгэм, Соёлын Зөвлөлийн 1996 оны 7 сарын 25ны өдрийн 1996/31 тоот тогтоол болон Хүний эрхийн Комиссын үйл ажиллагаагаар тогтоогдсон туршлагад үндэслэнэ.

(б) Зөвлөл нь хүний эрхийн үндэсний байгууллагуудын идэвхитэй оролцооны ач холбогдлыг хүлээн зөвшөөрөхийн хамт тэдгээрийн оролцоо нь 2005 оны 4 сарын 20-ны өдрийн 2005/74 тоот тогтоол болон Хүний эрхийн Комиссын үйл ажиллагааны тогтсон журмын дагуу явагдана.

ЭЭЛЖИТ ХУРАЛДААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БОЛОН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

Журам 8

(а) Зөвлөл нь товчоог сонгох, тухайн жилийн үйл ажиллагааныхаа хөтөлбөр болон хэлэлцэх асуудал ээлжит хуралдаан явагдах өдрүүдийг тодорхойлох, боломжтой бол тухайн жилийн үйл ажиллагаа дуусгавар болох өдрийг тогтоох, аливаа асуудлыг хэлэлцэх боломжит өдрүүд болон хуралдааны тоог тогтоох зорилгоор жил бүрийн эхэнд зохион байгуулалтын хуралдаан хийнэ.

(б) Тухайн хуралдаантай холбоотой зохион байгуулалт, дэг журмын асуудлуудыг хэлэлцэх шаардлагатай бол Ерөнхийлөгч тухайн хуралдаан явагдахаас 2 долоо хоногийн өмнө зохион байгуулалтын хуралдаан зарлан хуралдуулж болно.

ЕРӨНХИЙЛӨГЧ БОЛОН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ

Сонгууль

Журам 9

(а) Зөвлөлийн жил бүрийн эхний зохион байгуулалтын хуралдаанаар Зөвлөлийн Ерөнхийлөгч, 4 дэд ерөнхийлөгчийг гишүүдийн дундаас сонгоно. Ерөнхийлөгч болон Дэд Ерөнхийлөгчид Товчоог бүрдүүлнэ. 1 Дэд Ерөнхийлөгч нь илтгэгч байна.

(б) Зөвлөлийн Ерөнхийлөгчийг Африк, Ази, Зүүн Европ, Латин Америк болон Карибын орнууд, Баруун Европ болон бусад бүс нутгуудаас ээлжлэн сонгоно. 4 Дэд Ерөнхийлөгч нь Зөвлөлийн Ерөнхийлөгчийн харьяалагдаж байгаагаас бусад бүс нутгуудаас сонгогдоно. Илтгэгч нь бүс нутгуудаас ээлжлэн сонгогдоно.

Товчоо

Журам 10.

Товчоо нь үйл ажиллагааны зохион байгуулалт, дэг журмын асуудлуудыг хариуцна.

Үйл ажиллагаа явуулах хугацаа

Журам 11

Журмын 13 зүйлд заасны дагуу Ерөнхийлөгч болон ДэдЕрөнхийлөгч нар нь нэг жилийн хугацаагаар сонгогдоно. Тэд тухайн албан тушаалд дахин сонгогдохгүй.

Албан тушаалтнууд эзгүй байх тохиолдолд

Журам 12

Ерөнхийлөгч нь хуралдаанд буюу түүний зарим хэсэгт оролцох боломжгүй бол түүнийг эзгүйд орлон ажиллах хүнийг Дэд Ерөнхийлөгч нарын дотроос томилно. Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч нь Ерөнхийлөгчтэй нэгэн адил эрх, үүрэг хүлээнэ. Хэрэв 13 дугаар журамд заасны дагуу Ерөнхийлөгч үйл ажиллагаа явуулах боломжгүй тохиолдолд Хорооны бусад гишүүд шинээр Ерөнхийлөгч сонгогдох хүртэл ажиллах Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгчийг өөрсдийн дундаасаа сонгоно.

Ерөнхийлөгч болон Дэд Ерөнхийлөгчийг орлох

Журам 13

Ерөнхийлөгч буюу Дэд Ерөнхийлөгчийн аль нэг нь үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон эсвэл тэрээр Зөвлөлийн гишүүн аль нэг улсын төлөөлөл байхаа больсон, эсвэл тухайн улс Зөвлөлийн гишүүнээс гарсан бол Ерөнхийлөгч чөлөөлөгдөж, Шинээр сонгогдсон шинэ Ерөнхийлөгч үлдсэн хугацаанд ажиллана.

АЖЛЫН АЛБА

Ажлын албаны үүрэг

Журам 14

Хүний эрхийн дээд комиссар нь Зөвлөлийн ажлын алба байна. Ажлын алба нь Зөвлөлийн үйл ажиллагааг бүх талаар дэмжин, Зөвлөл, түүний байгууллага, хороодын баримт бичиг, тайлан, тогтоол шийдвэрийг хүлээн авах, НҮБ-ын албан ёсны хэлээр орчуулах, хэвлэх, түгээх болон зөвлөлийн баримт бичгүүдийн архивт хадгалах, хуралдааны тэмдэглэлийг бэлтгэх, орчуулах, хэвлэх, түгээх, хуралдааны үеэр хэлсэн үгийг орчуулах бусад бүх баримт бичгүүдийг Зөвлөлийн гишүүд болон ажиглагч нарт хүргэх үүрэгтэй.

ТАЙЛАН, ТЭМДЭГЛЭЛ

Ерөнхий Ассемблейд тайлагнах

Журам 15

Зөвлөл жилийн үйл ажиллагаагаа Ерөнхий Ассемблейд тайлагнана.

ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛИЙН НЭЭЛТТЭЙ БА ХААЛТТАЙ ХУРАЛДААНУУД

Ерөнхий зөрчмүүд

Журам 16

Хуралдааныг хаалттай явуулах онцгой шаардлагаас бусад тохиолдолд Зөвлөлийн хуралдаан нээлттэй явагдана.

Хаалттай хуралдаан

Журам 17

Зөвлөлийн хаалттай хуралдаанаас гарсан бүхий л шийдвэрүүдийг дараагийн нээлттэй хуралдааны эхэнд танилцуулна.

АЖЛЫН ЗОХИЦУУЛАЛТ

Ажлын хэсэг болон бусад зохион байгуулалтууд

Журам 18

Зөвлөл нь ажлын хэсэг байгуулах болон бусад хэлбэрээр үйл ажиллагаагаа зохион байгуулна. Энэхүү ажлын хэсэгт орж ажиллах эсэхийг гишүүд 7-р журмын дагуу шийдвэрлэнэ. Эдгээрийн ажиллах журам нь Зөвлөлийн үйл ажиллагааны журамд нийцсэн байна.

Хуралдааныг хүчинтэй гэж үзэх (кворум)

Журам 19

Зөвлөлийн гишүүдийн гуравны нэгээс дээш хувь нь хүрэлцэн ирсэн тохиолдолд Ерөнхийлөгч хуралдааныг нээж, хэлэлцүүлэгийг эхлүүлнэ. Аливаа шийдвэр батлахад гишүүдийн олонхи ирц шаардагдана.

Олонхийн санал

Журам 20

Зөвлөлийн шийдвэрүүд нь журмын 19-д заасны дагуу хуралдаанд оролцсон, санал өгсөн гишүүдийн ердийн олонхийн саналаар батлагдана.

Хавсралт 1

Зөвлөлийн үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу хянан хэлэлцэгдэж шинэчлэгдэх хүртэл үйл ажиллагаа явуулах тусгай үүрэг гүйцэтгэгчид

Гайти улсын хүний эрхийн асуудлаархи Ерөнхий нарийн бичгийн даргаас томилогдсон хараат бус шинжээч

Сомали улсын хүний эрхийн асуудлаархи Ерөнхий нарийн бичгийн даргаас томилогдсон хараат бус шинжээч

Бурунди улсын хүний эрхийн асуудлаархи хараат бус шинжээч

Либерт техникийн туслалцаа үзүүлэх болон зөвлөгөө өгөх асуудлаархи хараат бус шинжээч

Ардчилсан Конго улс дахь хүний эрхийн нөхцөл байдлын асуудлаархи хараат бус шинжээч

Хүний эрх болон олон улсын эв нэгдлийн асуудлаархи хараат бус шинжээч

Цөөнхийн асуудлаархи хараат бус шинжээч

Эдийн засгийн шинэчлэлийн бодлого болон гадаадын зээл тусламж, хөрөнгө оруулалтын хүний эрх ялангуяа эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хэрэгжилтэд үзүүлж буй сөрөг нөлөөний талаархи хараат бус шинжээч

Хүний эрх болон нэн ядуу байдлын асуудлаархи хараат бус шинжээч

Судан дахь хүний эрхийн нөхцөл байдлын асуудлаархи Тусгай илтгэгч

Мянмар дэх хүний эрхийн нөхцөл байдлын талаархи Тусгай илтгэгч

Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос улс дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаархи Тусгай илтгэгч

Палестины эзлэгдсэн нутаг дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаархи Тусгай илтгэгч (энэхүү тусгай илтгэгч нь 1967 онд томилогдсон бөгөөд булаан эзлэлт дуусгавар болох хүртэл ажиллана)

Зохистой орон байртай байх явдал нь зохистой амьжиргаатай байх эрхийн үндсэн нөхцөл болох асуудлаархи Тусгай илтгэгч

Үл тэвчих болон арьсны үзэл арьс өнгөөр ялгаварлан гадуурхах орчин үеийн хэлбэрийн асуудлаархи Тусгай илтгэгч

Шүүн таслах ажиллагаа явуулахгүйгээр цаазаар авах ял оноох болон цаазаар авах ялыг хилсээр гүйцэтгэх асуудлаархи Тусгай илтгэгч

Шашин шүтэх эс шүтэх эрх чөлөөний асуудлаархи Тусгай илтгэгч

Химийн хорт хаягдлыг хууль бусаар тээвэрлэх, аюултай бодис, хог хаягдлаас хүний эрхийн хэрэгжилтэд үзүүлж буй сөрөг нөлөөний асуудлаархи Тусгай илтгэгч

Хүний наймаа, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалах явдлын хохирогч нарын хүний эрхийн асуудлаархи Тусгай илтгэгч

Цагаачдын хүний эрхийн асуудлаархи Тусгай илтгэгч

Шүүх хуульчдын хараат бус байдлын асуудлаархи Тусгай илтгэгч

Терроризмтэй тэмцэхэд хүний эрх, үндсэн эрх чөлөөг хангах хамгаалах асуудлаархи Тусгай илтгэгч

Хүний сэтгэцийн болон биеийн эрүүл мэндийг дээд нөхцлөөр хангуулах эрхийн хэрэгжилтийн асуудлаархи Тусгай илтгэгч

Боловсрох эрхийн асуудлаархи Тусгай илтгэгч

Хоол хүнсний эрхийн асуудлаархи Тусгай илтгэгч
Хүүхдийг садар самуунд уруу татах, хүүхдийг биеийг нь үнэлүүлэх болон хүүхэд худалдаалах асуудлаархи Тусгай илтгэгч

Уугуул иргэдийн хүний эрх Үндсэн эрх чөлөөний асуудлаархи Тусгай илтгэгч

Эрүүдэн шүүх болон нэр төрийг нь гутаах хүнлэг бусаар хэрцгий харьцахтай холбоотой асуудлаархи Тусгай илтгэгч

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний сөрөг нөлөө, үр дагаврын асуудлаархи Тусгай илтгэгч

Үндэстэн дамжсан корпораци болон бусад бизнесийн үйл ажиллагаа ба хүний эрхийн асуудлаархи Ерөнхий нарийн бичгийн даргын Тусгай төлөөлөгч

Камбожи дахь хүний эрхийн нөхцөл байдлын асуудлаархи Ерөнхий нарийн бичгийн даргын Тусгай төлөөлөгч

Хүний эрхийг хамгаалагчдын хүний эрхийн асуудлаархи Ерөнхий нарийн бичгийн даргын Тусгай төлөөлөгч

Дотоод дахь дүрвэгсдийн хүний эрхийн асуудлаархи Ерөнхий нарийн бичгийн даргын Төлөөлөгч

Африк гаралтай хүмүүсийн асуудлаарх Шинжээчдийн Ажлын хэсэг

Хууль бусаар баривчлах асуудлаарх Ажлын хэсэг

Хүчээр алга буюу сайн дураар бус алга бологсдын асуудлаарх Ажлын хэсэг

Хөлсний этгээдүүдийг ард түмнүүдийн өөртөө засан тогтнох эрхийг хэрэгжүүлэхэд саад болох, хүний эрхийг зөрчих хэрэгсэл болгон ашиглах асуудлаарх Ажлын хэсэг